


Dräger Alcotest® 6820 Согтолт хэмжих төхөөрөмж

Dräger Alcotest® 6820 согтолт хэмжих төхөөрөмж нь мэргэжлийн чанарын өндөр түвшний шаардлага хангасан. Мэдрэгч нь цаг агаарын хүнд нөхцөлд хурдан бөгөөд нарийвчлал өндөр хариу гаргана.



Ач холбогдол

Аюулгүй байдлыг хангах

Архи, согтууруулах ундаа нь зам тээврийн болон ажлын байран дахь ослын хамгийн түгээмэл шалтгаануудын нэг юм. Dräger Alcotest® 6820 нь аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, архи, согтууруулах ундаа хэрэглэснээс үүдэн хүний биед гэмтэл учруулах, материаллаг хохирол, цаашлаад олон нийтийн нэр хүндийг алдахаас урьдчилан сэргийлэх боломжийг олгодог.

Хэрэглэхэд хялбар

Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж буй хүнтэй харьцах нь маш их анхаарал шаарддаг. Хэмжих төхөөрөмж хэрэглэхэд хялбар бөгөөд амьсгалаас согтууруулах ундааг энгийн бөгөөд хурдан шалгах боломжтой. Хэмжилтийн бүх функцийг ганц товчлуураар ажиллуулдаг. Ойлгоход хялбар текст мессеж болон шинжилгээний хариуг арын гэрэлтэй том дэлгэц дээр харуулна. LED гэрэл болон анхааруулах дохио нь туршилт дууссаныг илтгэнэ. Хоёр цэсийн товчлуур нь тохиргоо хийх, мэдээллийг бүртгэх ашиглагддаг.

Туршигдсан чанар

Электрохимийн мэдрэгчтэй Alcotest 6820 төхөөрөмж маш өндөр нарийвчлалтай. Олон жилийн эдэлгээ даах чадвартайгаас гадна -5 °C аас +50 °C хэмд ч итгэж болохуйц үр дүнг шүүрхай харуулна.

Зохимжтой загвартай

Alcotest 6820 нь хэрэглэгчид ээлтэй, эргономик загвартай. Түүний авсаархан хэлбэр нь түүнийг барихад хялбар болгодог бөгөөд үүнийг нэг гараараа хянах боломжтой. Контурынхаа ачаар амны хөндийг байрлуулна. Нэг удаагийн хошуу байрлуулах ажилбар нь харанхуйд ч хялбар байдаг. Хэрэглэсний дараа нэг удаагийн хошууг хялбар зайлуулах боломжтой нь эрүүл ахуйн үүднээс ашигтай юм.

Ажиллах хүрээ өргөн

IP 54 хамгаалалтын зэргийг хангасан тул чийгтэй нөхцөлд ажиллана.

Нэг удаагийн хошуу

Амаараа хүрэлцэж согтолтыг хэмждэг тул тусдаа савлагдсан байдаг нэг удаагийн хошуу ашигладаг нь эрүүл ахуйн нөхцөлийг дээд зэргээр хангадаг..

Мэдээлэл боловсруулах, бүртгэл

Alcotest 6820-ийн өргөтгөсөн санах ойн багтаамж нь 5000 хүртэлх түршилтын үр дүнг бүртгэх боломжтой. Зөөврийн үр дүн хэвлэгч рүү утасны принтер рүү өгөгдлийг шууд ямар нэгэн кабелгүй дамжуулах боломжтой. USB холболтоор дамжуулан үр дүнг компьютерт хуулах, эсвэл тохиргоо хийнэ.

Нэмэлт

Оосор нь Alcotest 6820-ийг зөөвөрлөх, хэрэглэхэд тохиромжтой болгодог.

Нэмэлтээр захиалах боломжтой бүтээгдэхүүн



D-9486-2014

Батарей

Цэнэглэх боломжтой батарей



ST-210-2004

Арьсан гэр

Бүснээс бэхлэх боломжтой



ST-8404-2006

Хэвлэгч

Согтолт хэмжих эсвэл мансууруулах бодис хэмжих төхөөрөмжтэй ажиллах боломжтой. 4 ширхэг AA батарейгаар ажиллана



ST-178-2004

Нэг удаагийн хошуу

Амьсгал буцаж үлээхгүй. Төхөөрөмжид суулгахад хялбар.

Техникийн үзүүлэлт

Хэмжилтийн үндэс	Зөвхөн спиртийг хэрэглээг таних электрохимийн мэдрэгч
Хэмжилтийн хүрээ	0 -аас 2.5 мг/л; давсан бол дохио өгнө
Дээж авах	Хэмжилт хийх хамгийн бага хэмжээнд дээж хүрмэгц шинжилнэ Идэвхгүй хэмжилт хийх боломжтой
Ашиглахад бэлэн болох Шалгах хугацаа	Асаасны дараа 2 секундийн дараа бэлэн болно 0 мг/л бол 3 сек, 0.5 мг/л бол 10 сек
Ашиглах температур	-5 аас +50 °C
Дэлгэц	LCD гэрэлтэй 41 мм x 24 мм (128 x 64 pixels)
LED	Анхааруулах дохионы 3 өнгөтэй
Дохио	Анхааруулах хэдэн төрлийн дуут дохиотой
Санах ой	Сүүлийн 5000 шалгалтын үр дүнг огноо болон цагтай хадгална.
Эрчим хүчний эх үүсвэр	2 ширхэг AA эсвэл NiMH батарей орно, цэнэгийн хэмжээ дэлгэц дээр харагдана. Ойролцоогоор 1500 шалгалт бүтэн цэнэгээр хийгдэнэ. Цэнэглэдэг батарей төхөөрөмжөөс шууд цэнэглэж болно. Нойтон эсвэл хуурай тест хийгээр үйлдэнэ
Тохиргооны хий	147 мм x 65 мм x 39 мм, 260гр
Хэмжээ, жин	Өөрийн цэсээр төхөөрөмжийн тохиргоо хийнэ (Код шаардана).
Тохиргоо	Нэмэлт компьютер шаардагдахгүй
Чичиргээ болон доргилт	EN 60068-2-6, EN 60068-2-27, EN 60068-2-64, MIL-STD 810F
Европын стандартад нийцсэн тэмдэглэгээ	EMC Directive
Мэдээлэл дамжуулах	USB to PC; optical interface for printer control
Стандарт	EN 15964 хангана
Хамгаалалтын зэрэг	IP 54

